

“ESG FINANCE” JSC

“И ЭС ЖИ ФАЙНАНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 -р сарын 30-ны өдөр

Дугаар: 03/01

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2024 оны 4 сарын 30-ны өдрийн тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бизнес төлөвлөгөө болон компанийн үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахад шаардлагатай бусад төсөл төлөвлөгөөг батлан зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР

“ESG FINANCE” JSC

“И ЭС ЖИ ФАЙНАНС” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 -р сарын 30-ны өдөр

Дугаар: 03/02

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ
ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2024 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай компанийн хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР

“ESG FINANCE” JSC

**“И ЭС ЖИ ФАЙНАНС” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 -р сарын 30-ны өдөр

Дугаар: 03/03

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйлүүд, 2024 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
4. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх Захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР

“ESG FINANCE” JSC

**“И ЭС ЖИ ФАЙНАНС” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 -р сарын 30-ны өдөр

Дугаар: 03/04

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ
НЭМЭГДҮҮЛЭХ, НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 31, 42 дугаар зүйлүүд, 2024 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан ажиллахад нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа тул компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэн таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ олон нийтэд болон хаалттай хүрээнд, стратегийн хөрөнгө оруулагчдад нэр заан эзэмшүүлэхээр таван тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
3. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР

“ESG FINANCE” JSC

**“И ЭС ЖИ ФАЙНАНС” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 -р сарын 30-ны өдөр

Дугаар: 03/05

Улаанбаатар хот

**ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ
ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62.1.8, 38 дугаар зүйлүүд, 2024 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргахтай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР